



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/112

Шивээговь сум

Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн
тооллогын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Геодези, зураг зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын нутаг дэвсгэрт байрлах геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Л.Чанцалмаа
(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүн: С.Отгонбаатар
(2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Нарийн бичгийн дарга: Т.Өлзийбуд
(Газрын даамал)

2.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын ажлын удирдамжийг 1 дүгээр, маршрутын зургийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэг тэмдэгтийн тооллогын ажлыг удирдамжийн дагуу чанартай, хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Л.Чанцалмаа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА Л.БАДАМХАНД



Сумын Засаг даргын 2024 оны
...08...сарын ...22...өдрийн ...1111...тоот
захирамжийн 1 дүгээр хавсралт



**ГЕОДЕЗИЙН ХАТУУ ЦЭГ ТЭМДЭГТИЙН
ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Газрын тухай хууль, Геодези зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийг бүс нутагтаа хэрэгжүүлэх, геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг жил бүр хийх, хадгалалт, хамгаалалт болон орчны нөлөөлөлд өртсөн байдлын талаар арга хэмжээ авч ажиллах, мөн цэг тэмдэгтийг сэргээн засварлаж хэмжилт зураглалын ажлыг хийж гүйцэтгэх нөхцөлийг алдагдуулахгүй байхад энэхүү ажлын гол зорилго оршино.

Хоёр. Зорилт

1. Цэг тэмдэгтийн хувийн хэргийн цэгцлэлт, бүрэн бүтэн байдлыг хангаж судалгаа бүртгэлийг урьдчилан бэлдэж, маршрутыг хавсаргасан байна.
2. Бүх цэг тэмдэгтийг бүртгэл судалгаа, координатын дагуу газар дээр нь үзэж, тоолж, зураг дарж харьцуулан баримтжуулна
3. Цэг бүр дээр тайлбар, тодруулгыг тэмдэглэсэн байна. Тухайлбал: устсан, гэмтсэн, нүүлгэн шилжүүлсэн гэх мэтээр;
4. Урьд онуудад шинээр суулгасан цэгүүдийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтыг шалгах, давхардал бий эсэхийг тодруулах /өөр нэршилээр бүртгэгдсэн эсэх/

Гурав. Ажиллах бүрэлдэхүүн

Газрын даамал, багийн Засаг дарга нар тухайн сумандаа тооллогын ажлыг чанартай, бодитой, үр дүнтэй зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд аймгийн Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн арга зүйн зөвлөгөө чиглэл өгч хамтран ажиллана.

Дөрөв. Тоолох, бүртгэх цэг тэмдэгтүүд

- ✓ Нийт 18 цэг

Тав. Хугацаа

- ✓ 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс 08 сарын 25-ний өдрийн хооронд


Зургаа. Явах чиглэл, маршрут

- ✓ Шивээговь суманд 250 км.




22

Сумын Засаг даргын 2024 оны
08 сарын 22 өдрийн 1116 тоот
захирамжийн 2 дугаар хавсралт



ШИВЭЭГОВЬ СУМЫН ГЕОДЕЗИЙН ЦЭГ ТЭМДЭГИЙН ТООЛЛОГЫН АЖЛЫН МАРШРУТ



ТАНИХ ТЭМДЭГ

- Сумын хил
- Нэгж талбар
- Геодезийн байнгын хатуу цэг
- Маршрут

1:230,000